



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/436

Булган сум

### Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2.1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан “Доройтсон бэлчээрийн газрыг нөхөн сэргээх, ойн зурвасын усалгааны зориулалтаар шинээр худаг гаргах (10 ш)” ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан “Баясах ус эрдэнэ” ХХК-тай 238,038,289 (хоёр зуун гучин найман сая гучин найман мянга хоёр зуун наян ес) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Шүрэнцэцэг)-д олгосугай.

2. Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ч.Шүрэнцэцэг), тус хөрөнгийг холбогдох сумдын данс бүртгэлд тусгуулахыг Орон нутгийн өмчийн газрын дарга (Т.Баттулга), хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг холбогдох сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль тогтоомж, стандарт, зураг, төсвийн дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг “Баясах ус эрдэнэ” ХХК-ийн захирал (Б.Батбаяр)-д даалгасугай.

4. Гэрээнд тусгах нөхцөл шаардлагыг хавсралтаар баталж, заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусган хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

6. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу аймгийн Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Э.Эрдэнэжаргал)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Сугар Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010596

Аймгийн Засаг даргын 2025 оны  
06 дугаар сарын 22-ны/ний өдрийн  
А/496 дугаар захирамжийн хавсралт



Гэрээнд тусгах нөхцөл шаардлага

| д/д | Нөхцөл шаардлага                    | Мөнгөн дүн  | Хариуцах албан тушаалтан       |
|-----|-------------------------------------|---|--------------------------------|
| 1   | 2                                   | 3   | 4                              |
| 1   | Захиалагчийн техник хяналтын зардал | Гэрээнд зааснаар  | Ч.Шүрэнцэцэг                   |
| 2   | Магадалшгүй ажил                    | Гэрээнд зааснаар  | Ч.Шүрэнцэцэг                   |
| 3   | Алданги                             | Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна. | Э.Эрдэнэжаргал                 |
| 4   | Чанарын баталгаа                    | Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.   | Э.Эрдэнэжаргал<br>Ч.Шүрэнцэцэг |
| 5   | Ажил гүйцэтгэх хугацаа              | Хуанлийн 92 хоног   | Ч.Шүрэнцэцэг                   |